


## Монголын эрдэмтэн мэргэдийн төвд хэлээр түүрвисан зохиол бүтээлийн дээжээс

Ламын гэгээн Лувсандаанзанжанцан /1639-1704/



Ламын гэгээн Лувсандаанзанжанцан

Энэ биеийг буй буй хэмээвч  
Буй бус, хоосон чанарт  
Эрхэн бурхныг хол хол хэмээвч  
Хол бус, өөрийн чинь сэтгэлд  
Энэ үгийг хэлсэн хэлсэн хэмээвч,  
Хэлсэн бус бичсэн мөн  
Инээдэм наадам ха ха хо хо хэмээвч  
Ха ха-г ухвал амгалан тэр.

/Лувсандаанзанжанцан/

### Ламын гэгээн Лувсандаанзанжанцан товч намтар

Эрдэнэ мэргэн Бандида Ламын гэгээн Лувсандаанзанжанцан (1639-1704) нь XI жарны шарагчин туулай жил буюу 1639 оны хаврын тэргүүн сарын шинийн 15-нд Халхын Хангай ханы өргөн цэцэрлэгт Чингисийн гуч дахь уе Лоёг эрх Цүхүрийн хөвүүн болон мэндэлжээ. Чингисийн гуч дахь үеийн хөндлөн Цүхүр ноёны хөвүүн Лувсандаанзанжанцан 1643 онд Түвдийн Банчин Эрдэнийн бошгоор Дашилхүмбэ хийдийн хамба асан Лэгцэглхүндэвийн хувилгаан хэмээн тодорчээ. Долоон настай хүү 1645 онд Гачин цорж Лувсаняринпилээс тойн хувраг болж Лувсандаанзанжанцан хэмээх сахилын нэр хүртсэн аж. Тэрээр 17 сүүдэртэйдээ (1655) Төвдийн Үй, Зангийн газар сургууль ломнир хийхээр морилж, 5-р Далай лам Лувсанжамц, Банчин эрдэнэ Лувсанчойжалцан нарт бараалхан, багш шавь барьж, номын мэргэд олноор чуулсан Лхас, Дашилхүмбийн газар сурлага боловсролоо дээшлүүлж, судар тарнийн болон чойрын номыг үзэж, эм, зурхайн эрдэмд

суралцсан байна. Ялангуяа Дашлхүмбийн чанга хатуу дэглэмтэй, нарийн ховор номтой Агба дацангийн суудал жавданд багтаж, гурван жил шашны зан үйл, равнай жинсрэг, хот мандлын тэг хэмжээ, өнгө будаг, хурал номын уншлагын ая дан, чагжа, цам тэргүүтнийг нарийвчлан судалжээ, Тэрээр Төвдийн Лхас, Дашлхүмбийн газраа долоон жил суугаад, 24 сүүдэртэйдээ (1662) Халхын газраа эргэн морилж, Бөөрөлжүүтийн (Цэрэлжүд буюу Насны шим үрэл) газар шинэ хийд Гандандашгэмпэллийн хэмээхийг цуглэж, гурван дацанг үүсгэж, Дашлхүмбэ, Сэра хийдийн жаяг дэгээр тогтоосон нь Зая бандидын үед бурсан хуврагийн нь тоо зургаан зууд хүрч байжээ. Ламын гэгээн нас сүүдэр 66 зооглохын үес өөрийн биенд мэс өргүүлэн таалал төгссөн аж. Халхын Өндөр гэгээн Занабазар нараас "Эрдэнэ бандид худагт", "Хамба номун хан", хэмээх цол алдрыг хүртэж байсан бөгөөд төвд ном сударт ханчин Чойжил хэмээн алдаршжээ.

### **Зохиол бүтээл:**

Ламын гэгээн төвд хэлээр 4 боть ном зохиосон нь хятад монгол бараар нийтэд тархжээ. Зарим судлаачид ламын гэгээний Га "КА" ботид нь 27, Ха "КНА" ботид нь 19, Га "GA" боть 18 нэрийн, На "NGA" боть 13 нэрийн ном байх бөгөөд нийт 4 ботид 77 нэрийн ном байдаг хэмээн үзсэн нь бий. Дөрвөөс дээш мөрийг чой гончиг (ном чухаг дээд) хэмээн үзвээс Га "КА" ботид нь **148** нэр төрөл, Ха "КНА" ботид-**36**, Га "GA" ботид-**18**, На "NGA" ботид **13**, бүгд 4 ботид нь нийт 215 нэр төрлийн ном одоогоор МҮҮН-н санд бүргэлтэй байна.

**Энэхүү дөрвөн ботид багтсан зохиолуудын төрөл зүйлийн хувьд нь ялган үзвэл:** зарлигийн ачит багш, бурхад догшидуудад өргөсөн залбирал магтаал, зориулгын ерөөл, сургаалын шүлэг, гүр дуулал, тайлбар, шашны зан үйлийн бясалгал бүтээлийн арга, балин тахил өргөхийн ёсон, нууц увдисын эрх эшийг нээх хөтлөх, эм, зурхайн ёс, даган соёрхлыг өгөх хүртээхийн ёсыг товч дэлгэр тайлсан олон бүтээл байна. Жишээ нь: Га "КА" ботид шашин номын мяндагтан тушаалтан ихэс лам нар, төр хар талын тайж тавнан, ноёд түшмэдээс эхлээд эмч, бичээч, зураач, хатад эхнэрүүд энгийн сүсэгтэн олон тэд бүгдийн хүсэлтийн дагуу бясалгын түгдамд 'амны уншлаганд' нь зориулан, хүссэн гүйсан тэр даруйд нь бичиж зохиож өгсөн бүтээлүүд байхад На "NGA" ботын 13 нэр төрлийн номын 7-н эмийн, 6-н зурхайн ном орсон байна.

**Лувсанданзанжалцан эдгээр бүтээл бүрийнхээ төгсгөлийн үгэнд өөрийнхөө нэрийг тэмдэглэхдээ их төлөв:**

"Багш дээдэс олны өлмийн лянхуаг шүтэж, нигурын рашааныг амссан Чингис тэнгэрийн тойн Лувсанданзанжалцан" хэмээгч бичив найруулав гэх буюу, эсвэл "Багш мэргэдийн зарлигийн ачаар чухалд тэжээгдсэн тэнгэрийн тойн Лувсанданзанжалцан", "Ялгуусан эцэг хөвгүүн (5-р далай лам Лувсанжамц, 4-р бичин эрдэнэ Лувсанчойжижалцан) хоёрын зарлигийн албат адаг эгэл тэнгэрийн тойн Лувсанданзанжалцан", гэхийн дээр, эсвэл бүр товчилж "Лувсан нэрийг баригч", "Тэжээх ухааныг баригч Лувсан нэрт", "Эмч тойн бээр", эсвэл бүр далдалж "Бандидын нэрийг баригч", "Туулайд арслан мэт бандид", гэх буюу, заримдаа ерийн энгийнээр "Лувсанданзанжалцан" буюу Бадмажалбозал", "Сумадидармадуаза", хэмээх нэр цолоо төвд, санскритээр нь ил далд болгож, өөрийгөө ихэд дорд газрыг барьж өгүүлсэн байдаг.

Та бүхэн МҮҮНС-ийн Төвд номын сан хөмрөгөөс Ламын гэгээн Лувсанданзанжалцангийн зохиосон дөрвөн ботиос захиалан уншихыг хүсвэл:

1. **Га боть "КА"-** NL10614, NL10615, NL10616, NL10623, NL10624, NL10629, NL10630, NL10631, NL10937, NL10938, NL10939,
2. **Ха боть "KHA"-** NL10617, NL10618, NL10619, NL10625, NL10626, NL10632, NL10940, NL10941, NL10942,
3. **Га боть "GA"-** NL10620, NL10628, NL10633, NL10634, NL10943, NL10944, NL10945,
4. **НА боть "NGA"-** NL10621, NL10622, NL10627, NL10946, NL10947, NL10948,

**Дээрх 4 ботид оногдох хувийн дугаараас сонголт хийнэ захиална уу**

Төвд хэлээр зохиол бүтээлээ тууривсан монгол эрдэмтэн лам нарын бүтээлийг нарийвчлан судлаж буй эрдэмтэн мэргэд эрхэм уншигч та бүхний гэгээн номын их үйлс тань улам гэрэлтэн гийх болтугай.

**МҮҮНС-ийн Төвд номын сан хөмрөгийн номын санч Б. Хүрэлцож**